

1. Байршил

1. Говь-Алтай аймгийн Шарга сумын Хамтын хүч багт инженерийн хийцтэй шинэ худаг барьж байгуулна.

2. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Бэлчээрт инженерийн хийцэт худаг шинээр гаргах ажлыг гүйцэтгэхэд худгийн цооног өрөмдөх, тоног төхөөрөмж суурилуулах ажилд тавих техникийн шаардлага MNS 6088:2011 стандартыг мөрдлөг болгон доорхи нөхцөлийг хангаж ажиллана. Үүнд:

1. Худгийг иж бүрэн барьж байгуулах /иж бүрдэлд: уст цэгийн хайгуул, цооног 245 мм - 325 мм диаметртэй өрөмдөх, шавхалт туршилтын ажил хийх, ус шахуурга, цахилгаан үүсгүүрийг сонгон суурилуулах, худгийн барилга, усан сан, халаалтын зуух, мал услах онгоц, талбай зэргийг барьж байгуулах/
2. Худгийн барилгын багтаамж 18 м³-ээс /Н, Y, Z/ багагүй, тоосго, блок, мод байна. Худгийн барилгад 1,5м³-ээс багагүй багтаамжтай ус хадгалах ган усан сан, дээгүүрээ модон тагтай, цахилгаан үүсгүүр, халаалтын зуухыг дотор нь байрлуулна. Худгийн барилга гадна талдаа хаяавчтай, барилгын модон хийц, усан сан, тоног төхөөрөмжүүдийн холболтын төмөр хийцүүдийг зэврэлтээс хамгаалж будсан байх шаардлагатай.
3. Мал услах онгоц нь 9м-ээс багагүй урттай, 400 мм-ийн голчтой хагас цилиндр ган яндан буюу цутгамал төмөр бетоноор хийж, мал услах онгоцны хоёр талд 2 м өргөнтэй цементэн хавтангаар талбайг бат бөх суурилуулна. Мал услах онгоцны ёроол нь ус юлэх налуутай байна. Худгийн мал услах талбай, барилга зэргийг ашиглагч хэрэглэгчтэй нь уялдуулан зохицуулах шаардлагатай.
4. Ашиглалтын ундарга нь 3м³-6м³ ус өгөх хүчин чадалтай байх, цооногийн техникийн паспортыг хөтөлж сумын Засаг даргын Тамгын газарт хүлээлгэн өгөх /хавсралт /
5. Хайгуулын ажлаар уст цэгийг тогтоох ажлыг хийж, энэ тухай актыг бүрдүүлэх /хавсралт1/ Уст цэгийн геоцахилгаан зүсэлтийг Хавсралт –ын дагуу бэлтгэх. Усгүй буюу хэт бага устай гэж тодорхойлогдсон газар өрөмдөж илүү зардал гаргахгүй байхад анхаарах, Ашиглаж болохуйц энгийн болон инженерийн хийцтэй худгийн дэргэд шинээр худаг гаргахгүй байвал зохино.
6. Худгийн цооногийн хийц зохиомжийг MNS6088-2010 стандартын шаардлагад нийцүүлэн, өрөмдлөгийн ажлын дараахь шавхалтын ажлын үр дүнгээр худгийн ундарга 0,6 л/с-ээс бага бол цооног ашиглах боломжгүй гэж үзэх ба Мэргэжлийн хяналтын байгууллагаар дүгнэлт гаргуулах шаардлагатай, тухайн гидрогеологийн нөхцөлд, усны динамик түвшин нь хамгийн бага гүнд байхад шаардлагатай ундаргыг хангасан байхаар тооцож, цооног өрөмдөх, худгийн цооногийн шүүрийн цувааны диаметр нь түүний дотуур ус шахуургыг саадгүй суулгах, дахин сугалах боломжтой байх, чанарын хувьд шаардлага хангасан ашиглах боломжтой уст үеийг бусад шаардлага хангахгүй уст үеэс сайтар зааглаж хаасан байх, худгийн цооногийг чулуулгийн уст үе, бусад үе давхаргын элс шавар гэх мэт сэвсгэр болон үйрмэг чулуу нурж унахгүй нөхцлийг хангахаар бодож суултын яндангаар сайтар хааж бэхлэх, шаардлагатай тохиолдолд шүүрийн цувааны доод амсрыг битүүлж таглах, цооногийн хийц зохиомж нь түүнийг ашиглах ба сэргээн засварлахад төвөгтэй биш байна. Өрөмдлөгийн ажлын журнал хөтөлнө. Энэ журналд өрөмдлөгийн ажлын талаархи тодорхой мэдээллийг тусгах /хавсралт 2/
7. Өрөмдлөгийн ажил дууссаны дараа шавхалтын ажлыг хийж гүйцэтгэх ба шавхалтын журналыг дэлгэрэнгүй үйлдэх /хавсралт 3/
8. Усны химийн болон бактериологийн шинжилгээг хийлгэж үр дүнг хавсаргах
9. Худгийн хүчин чадалд тохируулан шинэ ус шахуурга, цахилгаан үүсгүүрийг сонгон суурилуулах ажлуудыг гүйцэтгэнэ. Ус шахуурга, цахилгаан үүсгүүр нь барааны Олон улсын ISO-9001 стандарттай байх, Барааны гарал, үүслийн тодорхойлолт, Тухайн компаний бараа үйлдвэрлэх эрхийн бичиг, Нийлүүлэх барааны техникийн үзүүлэлтийг нотолсон үйлдвэрлэгч компаний хэвлэмэл танилцуулга, ашиглалтын заавар, Ашиглалтын зааврыг Монгол хэл дээр бэлтгэсэн байна.
10. Шинээр гаргаж буй худгийн цооногийг гаргаж, худгийн гүн, ундарга, статик, динамик түвшин зэргийг бүрэн тодорхойлсны дараа насосыг сонгон авч угсрах нь зүйтэй.

11. Худгийн моторын янданг заавал худгийн барилгаас гадагш гаргах эсвэл цонхтой байх, худгийн хаалгыг салхи уруу харуулах, худагт цонх гаргах
12. Худаг орчмын малчдын бүлэг, багийн Засаг дарга нарыг байлцуулан худаг хүлээх авах комисст хүлээлцэх, худгийн эзэмшил ашиглалтын талаар заавар өгч, эзэмшигчийг тодруулсан тухай хурлын тэмдэглэл авч ирүүлэх

ХУДГИЙН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ БОЛОН ШААРДЛАГА

№	Үзүүлэлтүүд	Тендерт оролцогчийн санал
1	Цооног өрөмдөх, цооногийг тоноглох	
1.1	Геофизикийн судалгаа хийж, худгийн байршлыг эцэслэн тогтоох	
1.2	Цооногийн ашиглалтын ундарга: 2м ³ -6м ³ ус өгөх хүчин чадалтай байна.	
1.3	Суултын яндангийн материал нь ган, ундны усанд хэрэглэхэд зөвшөөрөгдсөн хуванцар хоолой байна.	
1.4	Шүүрийн яндангийн материал нь ган, ундны усанд хэрэглэхэд зөвшөөрөгдсөн хуванцар хоолой байна.	
1.5	Ус өргөх яндангийн диаметр 25 мм-ээс багагүй, материал нь төмөр болон ундны усанд хэрэглэхэд зөвшөөрөгдсөн хуванцар хоолой ISO /хүйтний улиралд тэсвэртэй/	
1.6	Ус шүүх хайрга нь шигшсэн, мөлгөр хэлбэртэй, тоосонцор хольцгүй, мөхлөгийн хэмжээ 10-15 мм-ээс томгүй байна.	
1.7	Тунгаагуурын гүн: 2м-ээс багагүй	
1.8	Худгийг шавхалт хийж цэвэрлэх хугацаа: 24 цагаас багагүй	
1.9	Усны чанарын сорилт авах шинжилгээ хийлгэх	
1.10	Худгийг түр хугацааны тагаар тоноглох	
2	Худгийн байшин, усан сан, мал услах онгоц, талбай барих	
2.1	Худгийн байшингийн <ul style="list-style-type: none"> • Хэмжээ /дотор талдаа/: 3м х 3м, ханын өндөр шалнаас дээш 2 м • Материал: тоосго, блок, модон • Ханын зузаан: 38 см • Ханыг дотор талаас нь шавардаж, цагаан өнгөөр будна. • Худгийн дээр 30 см х 30 см хэмжээтэй нээлхийг тохируулан хийнэ. Нээлхийг худгийг засварлахад хэрэглэнэ. • Худгийн цонх нь 40см х 50 см хэмжээтэй, хамгаалалтын төмөр сараалжин хаалттай байна. /Цонхны байрлал нь мал услах онгоцны чанх харалдаа байрлана/ 	
2.2	Мал услах онгоцонд ус өгөх хоолой нь: 60мм диаметр тэй, гаднах ханаас 2м урттай гадагшилсан ган хоолойг цонхны доор гаргах	
2.3	Ундны ус авах хоолой нь: 60 мм диаметртэй, ган хоолойг цонхны доор гаргах /ундны ус авахад тохиромжтой байдлаар уртыг сонгох/	
2.4	40 мм-ийн диаметртэй цоорхойг генераторын утааг гадагшлуулах зорилгоор генераторын янданд яг тохируулан тохиромжтой байрлалд гаргана.	
2.5	Босоо суурьтай тоноглогдсон, гагнаж хийсэн, дотор талыг зэврэлтээс хамгаалсан 1,5м ³ -ээс багагүй багтаамжтай ган усан сан, дээгүүрээ модон тагтай	
2.6	Мал услах онгоцны: <ul style="list-style-type: none"> • Хэмжээ: 9м-ээс багагүй урттай, 400мм-ийн голчтой хагас цилиндр • Материал: ган хоолой буюу цутгамал төмөр бетон • Худгийн байшингаас 1-2 хэмийн налуутайгаар 2м-ийн зайд байрлуулна. • Онгоцны адагт үлдэгдэл ус юүлэх жижиг нээлхий гаргана. Нээлхийг онгоцонд ус өгөх үед эрэгдэж хаадаг байхаар хийнэ. • Усан сангаас мал услах онгоцонд ус дамжуулах хоолойг усан сангийн доод ёроолын усыг бүрэн шавхахаар байрлуулж гагнана. • Онгоцыг ган яндангаар хийсэн үед ирмэгийг аюулгүй болгож засна. 	

2.7	<p>Мал услах талбай:</p> <ul style="list-style-type: none"> • Хэмжээ: нийт уртын дагуу 2 талдаа 2 м-ийн өргөнтэй, зузаан нь 10 см • Материал: 150 маркаас доошгүй цемент хэрэглэнэ. Талбайг хийхдээ бетоныг төмөр тороор хүчитгэж өгнө. • Услах талбай нь худгийн байшин болон мал услах онгоцтой харьцуулахад бага зэрэг налуу байдалтай хийгдэх бөгөөд үлдэгдэл ус болон асгарсан ус юүлэхэд тохиромжтой байна. 	
3	Худгийн насос, бага оврын генератор, цахилгааны утас, хянах самбар	
3.1	Гүний насос: ISO9001 стандартын шаардлага хангасан, Монгол орны уур амьсгалын нөхцөлд ашиглах боломжтой байх	
3.2	Цахилгааны утас: 3 салаа, худагт ашиглах шаардлагыг хангасан, насосноос хянах самбар хүртэл үргэлжилсэн /залгаасгүй/, ус өргөх янданд 2 м тутамд хавчиж /туузаар ороож болохгүй/ тогтооно.	
3.3	Хянах самбар: Асаах унтраах товчлууртай, насос ажиллаж буйг /ногоон/, хүчдэл буйг /улаан/ гэрлээр асаах индикатортой, насос ажиллуулах асаагууртай.	
3.4	Бага оврын генератор: Бензинээр ажилладаг /ISO стандартын шаардлага хангасан/ Монгол орны уур амьсгалын нөхцөлд ашиглах боломжтой байх	
4	Худгийн ажлыг дуусгаж хүлээлгэж өгөх	
4.1	Талбайг цэвэрлэх /өрөмдлөгийн шлам, барилгын болон ахуйн хог хаягдал гэх мэт/	
4.2	Худаг , гүний насос, жижиг оврын генераторыг ажиллуулах, үйлчилгээ хийх, талбайн сургалт хийх	
4.3	Худгийн паспорт бэлтгэх	
4.4	Худгийн төсөвт өртөг	35 сая